



## **АмЧам Монгол АНУ-ын бизнес эрхлэгчдийн Монголд хийсэн айлчлалыг амжилттай зохион байгууллаа**

УЛААНБААТАР, Монгол улс - Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) нь 2018 оны 10-р сарын 15-17-ны өдрүүдэд анх удаа АНУ-ын Худалдааны Яамны итгэмжлэгдсэн бизнес айлчлалыг Монгол улсад зохион байгууллаа. Тус бизнес айлчлалын хүрээнд хөдөө аж ахуй, мэдээллийн технологи, харилцаа холбоо болон байгаль орчны техник технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Америкийн 5 компани Монгол улсад зочиллоо.

Тус бизнес айлчлал нь АмЧамын хувьд анх удаа зохион байгуулсан арга хэмжээ байсан бөгөөд өнгөрсөн арван жилийн хугацаанд болж буй анхны итгэмжлэгдсэн айлчлал гэдгээрээ онцлог байлаа. АНУ-Монгол Улсын хооронд бизнесийн түншлэлийг өргөжүүлэх хүчин чармайлтын хүрээнд тус бизнес айлчлалыг зохион байгуулж байгаа бөгөөд энэхүү айлчлал нь энэ онд хоёр улсын харилцаанд өрнөсөн олон чухал үйл явдлын үргэлжлэл болж байгаа юм. Тус бизнес айлчлал нь АНУ-ын бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдад бизнесийн харилцаа тогтоох, Монгол Улсын холбогдох төрийн байгууллагуудтай хийсэн тусгай арга хэмжээнд оролцох, АмЧам Монголын зүгээс Монгол Улсад Америкийн хөрөнгө оруулалтыг татах боломжийг таниулан сурталчлах зэрэг ховор боломжуудыг олгосон айлчлал болж өнгөрлөө.

Бизнес айлчлалын хөтөлбөрийн хүрээнд зочид Гадаад харилцааны яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Оюуны өмчийн газар, АмЧамын гишүүд зэрэг төрийн болон хувийн хэвшлийн нөлөө бүхий байгууллагуудтай уулзлаа. Айлчлалын гол онцлог нь ирсэн төлөөлөгчид Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж буй хувийн хэвшлийн төлөөлөлтэй ганцаарчлан уулзаж, ирээдүйд хамтран ажиллах талаар тодорхой ярилцах боломжийг олгосонд байлаа.

Мөн бизнес айлчлалд АНУ-ын Худалдааны Яамны Олон Улсын Худалдааны газрын Хятад, Монголын асуудал хариуцсан Төрийн нарийн бичгийн даргын орлогч ноён Алан Турлие болон Монголын асуудал хариуцсан дарга Жэн Гон Кросс нар оролцлоо. Бизнес айлчлалын бүрэлдэхүүнд Ag World International, The Blueshirt Group, Danaher Corporation, Global Star Inc., Waters Corporation гэх компаниудын төлөөлөгчид багтан олон чухал арга хэмжээнд оролцсон юм.

Энэхүү Бизнес айлчлал нь Монгол дахь АНУ-ын Элчин Сайдын Яамны дэмжлэгтэйгээр тун амжилттай болж өнгөрсөн ба ирсэн төлөөлөгчид Монгол улсад бизнесийн түншлэл бий болгох, ирээдүйд бусад олон чиглэлээр Монгол улсад АНУ-аас хөрөнгө оруулалт татах үндэс суурийг тавьж өглөө.

### **АмЧам Монголын тухай**

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны оффис юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.